



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/445

Улаанбаатар хот

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн
бүтэц, дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар, Цусны аюулгүй байдлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зураглалыг гуравдугаар, Цусны салбар төвийн дүрмийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Шинэчлэн баталсан дүрэм, бүтцийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг Цус сэлбэлт, судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал /Н.Эрдэнэбаяр/, аймаг, дүүрэг, сумын Нэгдсэн эмнэлгийн дарга, Цусны салбар төвийн эрхлэгч нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2016 оны 01 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт, 2016 оны А/137 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын
2020 оны 09 сарын 22 өдрийн 9/ тушаалын
нэгдүгээр хавсралт



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмийн зорилго нь Цус сэлбэлт судлалын үндэсний төв /цаашид Үндэсний төв гэх/ -ийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тодорхойлж, удирдлага, зохион байгуулалтын бүтцийг тогтоон хяналт тавих, эд хөрөнгийн эрх, тэдгээрээс үүдэх бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү дүрэм нь Үндэсний төвийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, санхүүжилттэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулах баримт бичиг мөн.

Хоёр. Байгууллагын үндсэн зорилго, чиг үүрэг

2.1. Үндэсний төв нь улсын хэмжээнд цусны донор элсүүлэлт, цус авах, цус, цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, чанар, аюулгүй байдал, цусны сонор сэрэмжийн тогтолцоо, цус сэлбэлт, судлалын чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах стандарт заавар, арга зүйн зөвлөмж боловсруулах, мэргэжлийн дүгнэлт гаргах, цус сэлбэлтийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, сургах, судалгаа, шинжилгээний ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага /тусгай мэргэжлийн төв/ байна.

2.2. Үндэсний төв нь Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Донорын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журам, тушаал шийдвэр, тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

2.3. Үндэсний төв нь цус цуглуулах суурин төв, цус цуглуулах хөдөлгөөнт хэсэг, Гамшгийн үед тусламж үйлчилгээ үзүүлэх нөөц төвтэй байна.

2.4. Үндэсний төв нь Улаанбаатар хот 13381, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 49 гэсэн хаягтай, Төвийн нэрийг англияар "National Center for Transfusion Medicine" гэж орчуулна.

2.5. Үндэсний төв нь тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцах данс, төвийн нэр, үйлчилгээний хамрах хүрээг илэрхийлсэн билэгдэл, тугтай байна.

2.6. Алсын хараа: Цус сэлбэлт судлалын чиглэлээр Ази тивдээ тэргүүлэгч байгууллага болно.

2.7. Эрхэм зорилго: Чадварлаг баг, дэвшилтэт технологи, инновацид тулгуурлан, үйлчлүүлэгчийн эрэлт, хэрэгцээг хангасан тусламж, үйлчилгээг үзүүлэхэд оршино.

2.8. Үнэт зүйл:

2.8.1. мэргэшсэн, ёс зүй, ур чадвартай баг;

2.8.2. удирдлагын манлайлал, хариуцлага, ил тод байдал;

2.8.3. тэгш хүртээмжтэй, чанартай, аюулгүй тусламж үйлчилгээ;

2.8.4. хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, технологи, материаллаг нөөц.

2.9. Үндэсний төв нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.9.1. Үндэсний төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан үндсэн эрхээс гадна дараах эрхтэй:

а/ эрхэм зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэдийн оролцоог дээшлүүлэх, хамтран ажиллах;

б/ цусны донор, цус авах үйл ажиллагаа, цус, цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, цус сэлбэлтийн тулгамдсан асуудлаар санал боловсруулж, холбогдох байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлэх;

в/ лавлагаа болон анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрийн цус сэлбэлт, судлал хариуцсан нэгж, цусны салбар төвийн үйл ажиллагаа, цусны аюулгүй байдлыг хангаж байгаа байдалд хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

г/ эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, ном товхимол, зөвлөмж, заавар хэвлүүлэх;

д/ цус сэлбэлт судлалын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх сургалт, хурал, гадаад болон дотоодын сургалт, семинар зохион байгуулах;

е/ гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай эрдэм шинжилгээ, судалгаа, хүний нөөц, технологи, инновацийн чиглэлээр хамтран ажиллах;

ж/ цусны донорыг алдаршуулах, урамшуулах зорилгоор эд материал, санхүү, сэтгэл зүйн тусламж үзүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олноос шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулах;

з/ хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

2.9.2. Үндэсний төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан үндсэн үүргээс гадна дараах үүрэгтэй:

а/ хүн амын дунд сайн дурын авлагагүй цусны донорын үйлсийг сурталчлах чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг Монголын улаан загалмай нийгэмлэг болон бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран зохион байгуулах, донороос цус авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, олгох;

б/ хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, гүйцэтгэлийг хянах;

в/ чиг үүрэг, эрхэм зорилго, салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангах;

г/ цус сэлбэлт судлалын чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн лавлагаа

шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх;

д/ цусны донорын бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох мэдээ, тайлан, цусны донорыг алдаршуулах, урамшуулахтай холбоотой баримтыг цаасан болон цахим хэлбэрээр архивлах;

е/ цус, цусан бүтээгдэхүүн, сорьцыг улсын хилээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

ж/ Улсын нөөцийн тухай хуулиар хүлээлгэсэн чиг үүргийг хэрэгжүүлэх;

з/ ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл аюулгүй ажлын байраар хангах, тэдний мэргэжил, мэдлэг, ур чадварын түвшинг тасралтгүй дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах;

и/ санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх;

к/ хууль тогтоомжоор олгогдсон бусад үүрэг.

2.10. Үндэсний төв нь зохион байгуулалтын бүтцийн хувьд бие даасан алба, тасгаас бүрдэх бөгөөд бүтцийн нэгжүүд нь дараах чиг үүрэгтэй байна:

2.10.1. Захиргаа, маркетингийн алба нь байгууллагыг удирдлагаар хангахад Ерөнхий захиралд дэмжлэг үзүүлэх, байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, хяналт тавих, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, статистик мэдээ, тайлан гаргах, нэгтгэн дүгнэх, мэдээлэх, байгууллагын үйл ажиллагааны өртөг зардлыг тооцох, төсвийн төсөл боловсруулах, хүний нөөцийн бодлого, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, байгууллагын маркетингийн үйл ажиллагааг хөгжүүлэх;

2.10.2. Цусны чанар, аюулгүй байдлын алба нь стандартыг мөрдүүлэх, чанарын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх, цусны сонор сэрэмжийн тогтолцоог хөгжүүлэх, халдварын сэргийлэлтийн хэрэгжилтийг хангах;

2.10.3. Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба нь Төвийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх, төгсөлтийн өмнөх болон дараах сургалт, эмч, эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалт зохион байгуулах, гадаад, дотоод хамтын ажиллагаа, мэдээллийн технологийг хөгжүүлэх, мэдээлэл, сүлжээний бэлэн байдлын хангах, сүлжээний тоног төхөөрөмж, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах;

2.10.4. Санхүү бүртгэлийн алба нь төвийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг бодитой тодорхойлох, төсвийн төсөл боловсруулах, зардлын үр ашгийг сайжруулах, холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад ач холбогдолтой, үнэн зөв мэдээллээр удирдлагыг хангах, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, бараа, материалын нөөц, хангамжийг хариуцах, хадгалалтын горимыг мөрдөх;

2.10.5. Сувилахуй, үйлчилгээний алба нь сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратегийн хэрэгжилтийг хангах, сувилахуйн тусламж, үйлчилгээний

ажиллагааны горимын хэрэгжилтэд хяналт тавихад дэмжлэг үзүүлэх болон байгууллагын цэвэрлэгээ, үйлчилгээг хариуцах;

2.10.6. Донор зохион байгуулалтын тасаг нь хүн амын дунд сайн дурын, авлагагүй цусны донорын ач холбогдлыг таниулах, цусны донорын эгнээг өргөжүүлэх, донор элсүүлэх, хадгалах үйл ажиллагааг олон талт хэлбэрээр зохион байгуулах, цус авах, цуглуулсан цус, сийвэн, эсийг хүйтэн хэлхээний горимыг мөрдөн тээвэрлэх, цусны донорын бүртгэл мэдээллийн санг баяжуулах, донорын сонор сэрэмжийг тогтолцоог хэрэгжүүлэх, төвийн хэмжээнд эмнэлгийн яаралтай тусламжийг хариуцах;

2.10.7. Нэгдсэн лабораторийн тасаг нь цуглуулсан цусны нэгж бүрд цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх, цусны бүлэг тодорхойлох шинжилгээ болон цус, цусан бүтээгдэхүүний чанарын хяналтын, иммуногематологийн лавлагаа шинжилгээ хийх. Цус сэлбэлт судлалын чиглэлээр үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөр хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд мөрдөж байгаа стандартын хэрэгжилтийг тогтвортой хангах;

2.10.8. Үйлдвэрлэлийн тасаг нь цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, олгох, бүтээгдэхүүний нөөц, хангамжийг зохицуулах;

2.10.9. Инженер техникийн тасаг нь төвийн тусламж үйлчилгээнд хэрэглэгдэж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, цусны Салбар төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулга, үйлчилгээ, засвартай холбоотой зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, тээврийн хэрэгсэл, барилга, байгууламжийн засвар, үйлчилгээ хийх, бэлэн байдлыг хангах.

Гурав. Удирдах бүрэлдэхүүн, түүний эрх хэмжээ

3.1. Үндэсний төвийг Ерөнхий захирал удирдах ба түүнийг Эрүүл мэндийн сайд томилж, чөлөөлнө. Ерөнхий захирал нь гадаад, дотоод үйл ажиллагаанд Төвийг төлөөлнө.

3.2. Ерөнхий захирлын эзгүйд түүнийг Захиргаа, маркетингийн албаны дарга, орлон ажиллах бөгөөд төсөв захиран зарцуулах, хүний нөөцийг томилох, чөлөөлөх эрхгүй байна.

3.3. Ерөнхий захиралд зөвлөх чиг үүрэг бүхий Удирдлагын зөвлөл байх бөгөөд, уг зөвлөлийн бүрэлдэхүүнд нэгжийн удирдлага, төвийн Үйлдвэрчний эвлэлийн салбар зөвлөлийн төлөөлөл орсон байна.

3.4. Ерөнхий захирал нь Удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно. Удирдлагын зөвлөл нарийн бичгийн даргатай байх бөгөөд саналын эрхгүйгээр хуралдаанд оролцоно.

3.5. Үндэсний төв нь Эрдмийн зөвлөлтэй байна. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг төвийн Ерөнхий захирал батална.

3.6. Ерөнхий захирал тушаал, Удирдлагын зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын тэмдэглэл гаргана.

3.7. Үндэсний төв нь дэргэдээ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн Салбар хороо, Санал гомдлын хороо болон шаардлагатай бусад орон тооны бус нэгжийг байгуулан ажиллуулж болно.

Ерөнхий захирал батална.

3.9. Ерөнхий захирлын эрх, үүрэг:

3.9.1. удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авилгаас ангид ажиллах;

3.9.2. Үндэсний төвийг удирдлага зохион байгуулалтаар хангах, Төсвийн ерөнхийлөн захирагчаар жил бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянуулах, биелэлтийг хангах, тайлагнах, үйл ажиллагааны үр дүнг хариуцах;

3.9.3. Үндэсний төвийн бүтцийн алба, тасаг, түүний удирдлагын үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, байгууллагын дотоод журам, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах;

3.9.4. албаны дарга, тасгийн эрхлэгч, ажилтныг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх;

3.9.5. төсвийг хууль тогтоомжийн хүрээнд захиран зарцуулах.

3.9.6. цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан Үндэсний төвийн орон тоо, ажиллагсдын цалин, хөлсийг тогтоох;

3.9.7. ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, урамшуулах, салбарын шагнал, төрийн одон, медалиар шагнуулахаар тодорхойлох, сахилгын шийтгэл ногдуулах, хөдөлмөрийн гэрээг цуцлах;

3.9.8. цусны донорыг алдаршуулах, идэвхжүүлэх зорилгоор Цусны албаны шагнал, онцлох тэмдэг бий болгох, цусны донорын хөдөлгөөнд үнэтэй хувь нэмэр оруулсан байгууллага, албан тушаалтан, иргэнийг шагнах, урамшуулах, төрийн одон, медальд тодорхойлох.

Дөрөв. Үндэсний төвийн санхүүжилтийн эх үүсвэр

4.1. Үндэсний төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

4.1.1. улсын төсөв;

4.1.2. үндсэн /төлбөртэй тусламж үйлчилгээний болон үйлчлүүлэгчийн захиалгаар хийх шинжилгээний орлого/ ба туслах үйл ажиллагааны орлого /байр, техник хэрэгсэл, бусад эд хөрөнгө түрээслүүлсний болон хууль тогтоомжид нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж олсон орлого гэх мэт/;

4.1.3. Төсвийн тухай хуульд заасны дагуу Монгол улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, тусламж;

4.1.5. олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

4.1.6. хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

Тав.Хөрөнгийн зарцуулалт

5.1. Ерөнхий захирал батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах бүрэн эрхийг эдлэх бөгөөд санхүүгийн баримтад нэгдүгээр, ахлах нягтлан бодогч хоёрдугаар гарын үсэг зурна.

5.2. Хандив, тусламж, төсвийн урамшууллын орлогыг холбогдох хууль, журмын

дагуу захиран зарцуулах эрхийг Ерөнхий захирал эдэлнэ.

5.3. Энэ журмын 5.1, 5.2-т заасан үйл ажиллагааг санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийг нотолгоонд тулгуурлаж, үр дүнгийн хувьд ижил бол эдийн засгийн үр ашигтайг сонгон санхүүжүүлэх зарчмыг мөрдлөг болгон хэрэгжүүлнэ.

Зургаа. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах


6.1. Энэ дүрэмд Ерөнхий захирлын саналыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулна.

---oOo---


Эрүүл мэндийн сайдын
2020 оны 09 сарын 26 өдрийн 2/ тушаалын
хоёрдугаар хавсралт 445




ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ



Эрүүл мэндийн сайдын
2020 оны 09 сарын 26 өдрийн 4/ тушаалын
гуравдугаар хавсралт 4/45



ЦУСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ МЭРГЭЖИЛ,
АРГА ЗҮЙН УДИРДЛАГЫН ЗУРАГЛАЛ



Эрүүл мэндийн сайдын
2020 оны 09 сарын 02 өдрийн А. тушаалын
дөрөвдүгээр хавсралт

ЦУСНЫ САЛБАР ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмийн зорилго нь Цусны салбар төв /цаашид Салбар төв гэх/ -ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц, эрх, үүргийг тодорхойлж, үйл ажиллагааны чиглэлийг тогтоон, хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү дүрэм нь Салбар төвийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалттай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулах баримт бичиг мөн.

Хоёр. Цусны салбар төвийн зохион байгуулалт, үйл ажиллагаа

2.1. Харьяалах нутаг дэвсгэртээ цусны донорын сургалт, сурталчилгаа, донор элсүүлэлт, хадгалалтыг удирдан зохион байгуулах, цус авах, цус, цусан бүтээгдэхүүн бэлтгэх, нийлүүлэх болон цусны аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий аймаг, дүүрэг, сумын Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн бүтцийн нэгжийг Цусны салбар төв гэнэ.

2.2. Салбар төвийн байр, дэд бүтэц, хүний нөөц, тоног төхөөрөмжийг бүтэц, үйл ажиллагааны стандарт, Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу зохион байгуулж, зохион байгуулалтын бүтэц, орон тоог аймаг, дүүрэг, сумын Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн дарга /ерөнхий эмч/-ийн тушаалаар батална.

2.3. Салбар төвийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлахдаа дараах жишгийг баримтална:

2.3.1. Аймаг, дүүргийн Салбар төв нь бие даасан тасаг байх;

2.3.2. Аймаг, дүүргийн Салбар төв орон тооны хувьд:

- Эрхлэгч эмч -1;
- Их эмч -1;
- Тусгай мэргэжилтэн 2 -4 (хэрэгцээгээр);
- Туслах ажилтан (хэрэгцээгээр).

2.3.3. Сумын Эрүүл мэндийн төвийн дэргэдэх Салбар төв орон тооны хувьд:

- Их эмч 0.5 -1;
- Тусгай мэргэжилтэн 1 -2 (хэрэгцээгээр);
- Туслах ажилтан (хэрэгцээгээр).

2.4. Салбар төвийн эрхлэгч, их эмч, тусгай мэргэжилтэн нь цус сэлбэлтийн чиглэлээр төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан байна.

2.5. Цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх, цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох шинжилгээг аймаг, дүүрэг, сумын Нэгдсэн эмнэлгийн лабораторит

хийнэ. Дээрх шинжилгээг хийх лабораторийн эмч, лаборант нь цус сэлбэлтийн чиглэлээр төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан байна.

2.6. Салбар төвийн удирдлагыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

2.6.1. Орон нутгийн түвшинд цусны аюулгүй байдлыг тухайн Салбар төвийн харъяалагдах аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн удирдлага хариуцна.

2.6.2. ЦССҮТ нь цусны салбар төвийн үйл ажиллагаа, цусны аюулгүй байдлыг хангаж байгаа байдалд хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, ажлыг нь дүгнэн урамшуулна.

2.6.3. Салбар төвийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдлагыг эрхлэгч /их эмч/ хэрэгжүүлэн, үйл ажиллагааны тайланг харъяалах эрүүл мэндийн байгууллага, ЦССҮТ-д тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

2.6.4. Аймгийн Салбар төв нь орон нутгийн засаг, захиргаа, нутгийн өөрөө удирдах байгууллага, Эрүүл мэндийн газар болон эмнэлгийн цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлтэй үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллана.

2.6.5. Салбар төв нь аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран сумын түвшинд цусны аюулгүй байдлыг хангах талаарх Эрүүл мэндийн сайдын тушаал, шийдвэрийн хэрэгжилт, цусны донорын бүртгэл, судалгаа, цусны хүүдий, урвалж, оношлуурын иж бүрдлийн бэлэн байдалд хяналт тавина.

2.7. Салбар төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

2.7.1. Харъяалагдах эрүүл мэндийн байгууллагын төсөв;

2.7.2. Төлбөртэй тусламж үйлчилгээний орлого;

2.7.3. Төсвийн тухай хуульд заасны дагуу Монгол улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээдээс цусны донорын эгнээг өргөжүүлэх, цусны албаны үйл ажиллагааг дэмжих зорилгоор өгсөн хандив, тусламж;

2.7.4. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

2.7.5. Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

Гурав. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

3.1. Энэ дүрэмд ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын саналыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулна.